



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/78

Улаанбаатар хот

“Элсэлтийн журам шинэчлэн батлах тухай”


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан журмыг 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Б.Гантулга/-т даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны “Элсэлтийн журам батлах тухай” А/129 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН



ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ ТӨРИЙН ӨМЧИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд /цаашид “сургууль” гэнэ/ ерөнхий боловсролын сургуулийн 5, 8 дугаар анги төгсөгчдөөс суралцагч элсүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Сургуульд суралцах хүсэл сонирхолтой, энэхүү журмын хоёрдугаар зүйлд заасан шаардлага хангасан суралцагчийг сонгон шалгаруулалж элсүүлнэ.
- 1.3. Сургуулийн удирдах зөвлөл нь олон улсын хөтөлбөрөөр хичээллэхэд тавих нийтлэг шаардлага, хичээлийн байр, анги, танхимын багтаамжид нийцүүлэн суралцагч элсүүлэх хяналтын тоо, элсэлтийн шалгалтын тов, босго оноог жил бүр тогтооно.
- 1.4. Сургуулийн удирдах зөвлөл нь байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх үед элсэлтийн шалгалтыг зохион байгуулах оновчтой хувилбарыг гаргаж, зохион байгуулалтыг хийнэ.
- 1.5. Элсэлтийн шалгалтын дэгийг сургуулийн захирлын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэж, захирлын тушаалаар баталж мөрдөнө.
- 1.6. Элсэлтийн шалгалтын дэгт: шалгалт авах хичээлийн агуулга, багтаамж, шалгалтын бэлтгэл, сэдэв боловсруулалт, нууцлал, шалгалтын үргэлжлэх хугацаа, шалгалтын явцын зааварчилгаа, зөвшөөрөх болон хориглох зүйлс, шалгуулагчийн болон шалгагчийн эрх үүрэг, хүлээх хариуцлага, шалгалтын засалт, дүнг мэдээлэх, санал гомдол шийдвэрлэх, тайлагнах, архивлах зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан байна.
- 1.7. Элсэлтийн шалгалт нь хүүхдийн сурч боловсрох эрхийг дэмжсэн, ил тод, шударга, нээлттэй, тэгш байдлыг хангасан, хараат бус байна.

Хоёр. Элсэлтийн шалгалтад орох шалгуулагчдад тавих шаардлага

- 2.1. Ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар анги, 8 дугаар ангийг тухайн хичээлийн жилд төгссөн байх.
- 2.2. 6 дугаар ангид элсэхийг хүсэгчийн ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар ангийн жилийн эцсийн үнэлгээний дундаж 90.0 хувь, түүнээс дээш байх.
- 2.3. 9 дүгээр ангид элсэхийг хүсэгчийн Ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар ангийн жилийн эцсийн үнэлгээний дундаж 80.0 хувь, түүнээс дээш байх.

Гурав. Элсэлтийн шалгалт зарлах, бүртгэх

- 3.1. Элсэлтийн шалгалтыг хичээлийн жил дууссанаас хойш хуанлийн 21 хоногт багтаан зохион байгуулна.
- 3.2. Орон нутгийн онцлог болон энэхүү журмын 4.8-д заасны дагуу мэргэжлийн байгууллагатай хамтран элсэлтийг зохион байгуулж байгаа зэргээс шалтгаалан элсэлтийн шалгалтын хугацааг өөрчилж болно.

- 3.3. Элсэлтийн бүртгэл, шалгалтын тов, суралцагч элсүүлэх хяналтын тоог шалгалт авах өдрөөс 14 хоногоос доошгүй хугацааны өмнө сургуулийн цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгслээр зарлана.
- 3.4. Элсэлтийн шалгалтын бүртгэлийг нэгдсэн журмаар цахимаар бүртгэн, сургууль тус бүр шалгалтыг зохион байгуулна.
- 3.5. Элсэлтийн шалгалтын бүртгэлд боловсролын удирдлага, мэдээллийн системийн мэдээллийг ашиглаж болох бөгөөд төрсний гэрчилгээ, суралцагчийн хувийн хэрэгтэй мэдээллийг тулган баталгаажуулна.

Дөрөв. Элсэлтийн шалгалт зохион байгуулах

- 4.1. Элсэлтийн шалгалтыг тухайн сургуулийн захирлын тушаалаар байгуулсан Ажлын хэсэг хариуцан зохион байгуулна.
- 4.2. Шалгалтын сэдэв боловсруулах, батлах, танилцах, хамгаалахтай холбоотой асуудлыг Ажлын хэсэг хариуцна.
- 4.3. Тухайн орон нутагт байрлах сургуулиуд 6 дугаар ангийн суралцагчдын элсэлтийн шалгалтыг ижил цаг хугацаанд нэгэн зэрэг зохион байгуулна.
- 4.4. 9 дүгээр ангийн суралцагчдын элсэлтийн шалгалтыг ижил цаг хугацаанд нэгэн зэрэг зохион байгуулна.
- 4.5. Ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар анги төгсөгчдөөс математикийн хичээлээр элсэлтийн шалгалт авна.
- 4.6. Ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар анги төгсөгчдөөс 2 шалгалт авна. Нэгдүгээр шалгалт математик - байгалийн ухааны нэгдмэл агуулгаар, хоёрдугаар шалгалт англи хэлний шалгалт байна.
- 4.7. Ажлын хэсэг шалгалттай холбоотой нууцлал, суралцагчдын шалгалтын материалын засалтын үнэн зөв, ил тод байдлыг хангаж, энэхүү журам болон элсэлтийн шалгалтын дэгийг мөрдөж ажиллана.
- 4.8. Шаардлагатай тохиолдолд сургууль нь элсэлтийн шалгалтыг зохион байгуулахад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

Тав. Элсэн суралцах шалгалтын дүн гаргах, шалгуулагчийг баталгаажуулах

- 5.1. 6 дугаар ангид элсэн суралцах шалгуулагчдыг элсэлтийн шалгалтад авсан оноогоор эрэмбэлж, хяналтын тоонд багтсан шалгуулагчдыг элсүүлнэ.
- 5.2. 9 дүгээр ангид элсэн суралцах шалгуулагчдын 2 шалгалт тус бүрийн анхны оноог хэмжээст оноо руу шилжүүлнэ. Энэхүү журмын 1.3-д заасан босго оноог давсан суралцагчдыг **хоёр шалгалтын хэмжээст онооны дунджаар** нь эрэмбэлж, хяналтын тоонд багтсан суралцагчдыг элсүүлнэ.
- 5.3. Элсэлтийн шалгалтын дүнг үндэслэн сургуулийн захирлын тушаалаар элсүүлэх суралцагчдын нэрсийг баталгаажуулна.